

ӨГҮҮЛЭЛ

**Бүгд Найрамдах Турк Улс дахь улс төрийн
намын үүсэл, хөгжил****Чулуунбаатарын Цэрэннадмид**

*Доктор Ph.D, Гуравдагч хөрш орон судлалын салбарын эрхлэгч,
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Улаанбаатар, Монгол Улс
tserennadmidch@mas.ac.mn*

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Бүгд Найрамдах Турк улс (БНТУ) дахь улс төрийн намуудын үүсэл, хөгжлийн талаар тэр дундаа Бүгд Найрамдах улс байгуулсан цаг үе буюу дотоод улс төрийн амьдралд М.К.Ататуркээр удирдуулсан улс төрийн хүчнээс гадна үзэл, хандлагаараа ялгаатай нийгмийн бүлгүүд үүсэж, оршин байхын төлөө тэмцэж, зарим тохиолдолд хүчээр хаагдах хүртэл олон үйл явдал өрнөсөн, өвөрмөц үеийг сонгон судлахыг зорив.

Исламын шашинтай боловч барууны чиг баримжаатай хөгжлийн зам сонгосон Турк улсын хувьд чухамхүү улс төрийн нам, олон намын тогтолцоо бүрэлдэн бий болсон түүхэн үйл явцтай холбогдох архив болон судалгааны мэдээлэл түлхүү ашиглалаа.

Ингэхдээ БНТУ-ын түүхийн чухам хэдий үед улс төрийн ямар нам, бүлэг бий болж, дотоод улс төрийн амьдралд ямар байр суурь эзэлж, хэрхэн нөлөөлж, ямар нийгмийн бааз суурь, бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалтын шинж төрх, улс төрийн үйл ажиллагааны арга хэлбэрийг мөрдөж байсан талаар тайлбарлалаа.

Сэдвийг сонгож авахдаа: нэгдүгээрт, Турк улсад сонгодог утгаараа улс төрийн анхны нам үүссэн шалтгаан, түүхэн нөхцөлийг харуулах, хоёрдугаарт, XX зууны Туркийн улс төрийн намын үйл ажиллагааг зохицуулж байсан хууль, эрх зүйн орчны онцлогийг харуулах гуравдугаарт, олон намын тогтолцоо үүсэн, бүрэлдсэн нөхцөлийг тодотгох, дөрөвдүгээрт, 1990 оноос хойших Туркийн улс төрийн намын тогтолцооны төлөвшил, онцлогийг харуулах зорилтуудыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үгс: Улс төрийн нам, үзэл суртал, хөгжлийн хандлага, сэтгэлгээний түүх, түүхийн үечлэл



Оршил

Хүн төрөлхтний улс төрийн сэтгэлгээний түүхэн хөгжлийн явцад улс төрийн намыг үзэх үзэл нарийн, төвөгтэй замыг туулж, олон сорилт бэрхшээлтэй тулгарч, цаг үеийн олон шалгуурыг даван, боловсронгуй болсоор иржээ. Улс төрийн намын тухай өнөөгийн ойлголтын түвшинд барууны эрдэмтдийн онолын судалгаа чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Бүгд Найрамдах Турк Улсыг (БНТУ) байгуулсан 1920-иод оны үндэсний хувьсгалын нэг гол үр дүн бол хуучин нийгмийн дутагдлыг арилгах, шинэчлэх арга зам хайсан шинэчлэгчдийг төрүүлсэн явдал байв. Чухам тэдгээр шинэчлэгчдийн дундаас тухайн үеийн Туркийн нийгэм, улс төрийн амьдралд хэд хэдэн улс төрийн бүлэг, хөдөлгөөн төрөн гарч, зохион байгуулалтад орох оролдлогуудыг хийж эхэлжээ. Энэ үйл явдал БНТУ-д сонгодог утгаараа улс төрийн нам байгуулагдах эх үндсийг тавьсан бөгөөд бүтэн зууны туршид нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоо болон төлөвших үйл явц үргэлжилж, өнөө хэр нийгэм, улс төрийн амьдралд нь чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

Тэр дундаа 1940-1990-ээд оны дунд үе хүртэлх хугацаанд тус улсад өрнөсөн олон намын тогтолцооны хөгжил, хэдхэн жилийн дотор 30 гаран улс төрийн хүчин байгуулагдаж, засгийн эрх барьж байсан улс төрийн хүчний шахалт, хязгаарлалтад өртөж, хууль шүүхийн байгууллагын шийдвэрээр хаагдаж, эсвэл намын нэр, удирдлагаа өөрчлөх байдлаар дахин

улс төрд орох оролдлого хийж байсан зэрэг нь улс төрийн үзэгдлийн хувьд сонирхол татахуйц, бодитой оршиж байсан юм.

Турк судлаачдын хувьд улс төрийн үзэгдлийн түвшинд бодит хэлбэрээ олоод байсан олон намын тогтолцоог ойлгох, түүний төлөвшил, хөгжилд нөлөө үзүүлж буй улс төрийн дотоод орчин, хүчин зүйлийг тусгайлан судлан шинжлэх чиглэлд анхаарал хандуулж байжээ. Тухайлбал 1983 оноос хойш Турк дахь улс төрийн намын зохицуулалтын хязгаарлагдмал байдал болон улс төрийн намуудын зохион байгуулалт, үйл ажиллагаа хоорондын уялдаа, холбогдон гарах харилцааг тодорхойлохыг зорьсон *Эргүн Өзбудун*, *Сабри Саяал*, *Пэлин Аялин*, *Мусил* зэрэг турк судлаачдын судалгаа зонхилж байна. Эдгээр судлаачид нэг намын тогтолцоо, нэг намын дарангуйлал бүхий улс төрийн тогтолцооны талаар судалдаг барууны судлаачид, тэр дундаа Т.Ж.Пемпелийн нэг нам ноёлсон улс төрийн тогтолцоо, байгууллын талаах үзэл баримтлал, К.Ф.Грийнийн харьцуулсан улс төр судлал – урт хугацаанд ноёрхлоо тогтоосон улс төрийн хүчний онцлог зэргийг түлхүү судалж, Турк Улсын улс төрийн амьдрал тэр дундаа 2000-аад оноос хойш төрийн эрх барьж буй улс төрийн хүчний онцлог, эрх мэдлээ хэрэгжүүлэх үзэл суртлын болон шашны үнэт зүйл итгэл үнэмшлийн талаарх судалгааг эрчимтэй хийж байна.

М.К.Ататурк тус улсад улс төрийн

нам сонгодог утгаараа байгуулагдах үндэс суурийг 1923 онд анхлан тавьсан бөгөөд түүний байгуулсан Бүгд найрамдахчуудын ардын нам (БНАН) болон бусад улс төрийн бүлэглэл, хөдөлгөөн нь 600 жил оршин тогтносон эзэнт гүрний суурин дээр бүгд найрамдах улсыг байгуулан, хөгжлийн замаа сонгосон Туркийн ард түмний үндэсний ухамсар сэргэх, шинэ нам төрөн гарах угтал болжээ. Энэ нам хожим тус улсын төрийн эрхийг 1925-1950 оны хооронд дангаараа барьж байсан бол 1960-1970-аад оны сүүл хүртэл бусад улс төрийн хүчинтэй хамтарсан засгийн газар байгуулж төрийн эрх барьж байсан бөгөөд өдгөө Турк улсын улс төрийн амьдралд чухал үүрэгтэй, хүчирхэг улс төрийн сөрөг хүчний нэг хэвээр байна.

1950-иад оны эхэн үеэс нэг нам буюу зөвхөн БНАН-ын засаглалыг шүүмжилж, түүнийг өөрчлөн ардчилсан, олон ургалч үзэл бүхий улс төрийн тогтолцоонд шилжих хэрэгтэй хэмээн үзэх улс төрийн нам, бүлэглэл олноор гарч эхлэв. Гэхдээ

эдгээр намуудын үйл ажиллагаа нь сонгодог утгаараа улс төрийн үзэл баримтлал, зарчмын хувьд ялгарсан бус, зөвхөн нэг намын тогтолцоог шүүмжилсэн, эсэргүүцсэн, ард нийт - улс төрийн бүлэглэлийн үзэл бодлын түгээмэл үнэлэмжид тулгуурлаж байв. Өөрөөр хэлбэл, тухайн үеийн улс төрийн намуудын төлөөлөл нь баруун, зүүний сонгодог үзэл, онол дагахаас илүүтэй цаг үеийн нийгэм, улс төрийн уур амьсгалыг шууд хүлээн авч, намын удирдагчийн үзэл бодлыг дэмжих байдлаар гол цөмөө бүрдүүлж байсан хэмээн Турк судлаачид үзэж байв. 2000-аад оны дунд үед Туркийн улс төр судлаач, германы эрдэмтэн, судлаачдын дунд улс төрийн нам, сонгуультай холбоотой, цаашлаад улс төрийн манлайлал, төвлөрөл, ардчилсан бус зохион байгуулалтын бүтэц үүсэн бүрэлдэх шалтгаан, намын гишүүдийн эрх, нэр дэвшүүлэх бодлого, намын санхүүжилт босгох зэрэг асуудлыг түлхүү судалж эхэлсэн байна.

1.1 Улс төрийн намын үйл ажиллагаатай холбогдох хууль эрх зүйн зохицуулалт

Турк улс 1961 онд шинэ Үндсэн хуулиа баталж, мөрдөж эхэлсэн цаг үеэс эхлэн улс төрийн намуудыг “ардчилсан улс төрийн амьдралын салшгүй хэсэг” хэмээн үзэх болсон юм. Гэхдээ 1960-аад оноос хойш Туркийн улс төрийн намын үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүй, механизм нь хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн

гэхээс илүү хатуу, чанга арга барил, зарчмыг баримтлах болсон хэмээн үзэх судлаачид цөөнгүй байдаг.

1961 онд Үндсэн хуульдаа анх удаа улс төрийн намыг холбоодоос өөр хууль эрх зүйн статустай байхаар хуульчилсан юм.¹ Улс төрийн нам байгуулах, намын гишүүнчлэл болон улс төрийн намуудад төрөөс

1 <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.2709.pdf> (БНТУ-ын 1982 оны Үндсэн Хууль, 69-р зүйл)

жилд нэг удаа олгох тусламж,² улс төрийн намуудад хориглох үйл ажиллагаанууд,³ улс төрийн намуудын үйл ажиллагаанд тавих хяналт, улс төрийн намуудын данс, Үндсэн хуулийн шүүхээр улс төрийн намыг татан буулгах, тараахтай холбогдох зохицуулалтууд энэхүү Үндсэн хуульд тусгалаа олсон байв.

Өдгөө Турк улсын хувьд улс төрийн намын үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой хууль, эрх зүйн үндсэн баримт бичгүүдэд: *Үндсэн Хууль (1961), Улс төрийн намын тухай хууль (1965, 1983), Парламентын (1983) болон Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай (2012) хуулиуд, Сонгуулийн Ерөнхий Хорооны шийдвэрүүд, Үндсэн хуулийн шүүх, Хүний эрхийн асуудал хариуцсан Европын Шүүх (ECtHR) зэрэг байгууллагын албан ёсны шийдвэрүүд хамаарна.*

1983 онд батлагдсан *Улс төрийн намын тухай хуульд* нийт 23 удаа өөрчлөлт оруулсан байдгаас зарчим, агуулгын хувьд томоохонд тооцогдох 4 гол өөрчлөлтийг 2010-2018 онуудад хийсэн байна.

“Иргэд сонгох, сонгогдох, бие даан эсвэл улс төрийн намд нэгдэх замаар улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхтэй... гэж 1982 оны Үндсэн хуульд заасан байдаг. Үүний дагуу гадаад улс оронд амьдарч буй Турк улсын иргэд 1995 онд хийсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд

сонгуульд санал өгөх эрхтэй болсон ажээ.⁴

Улс төрийн намууд нь хуулийн этгээд хэмээн тодорхойлогддог бөгөөд Улс төрийн намын тухай хуулиар парламентын болон орон нутгийн сонгуульд мөрийн хөтөлбөрөө сурталчлах, улс орон даяар үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар улс орны “соёл иргэншлийн түвшин”, “ардчилсан дэг журам”, “үндэсний хүсэл зоригийг төлөвшүүлэх”-д өөрсдийн хувь нэмрийг оруулах үүрэгтэй тухай заажээ.

Улс төрийн намд элсэх насны хязгаарыг 1999 онд хийсэн нэмэлт, өөрчлөлтөөр 21 нас байсныг 18 нас болгов.⁵ Улс төрийн намын гишүүн болох насны шаардлагыг хангасан 30 болон түүнээс дээш тооны Турк улсын иргэн нэгдэж, улс төрийн нам байгуулж болно. Улс төрийн нам нь Дотоод Хэргийн Яаманд улс төрийн нам үүсгэн байгуулах баримт бичгээ, тус яамны зүгээс шаардах холбогдох бусад баримт бичгийн хамт өргөн барьснаар албан ёсоор хуулийн этгээд болно.⁶

Улс төрийн намын үйл ажиллагаатай холбоотой аливаа өөрчлөлтийг Ерөнхий Прокурорын газар давхар хянадаг бөгөөд намын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтад орсон аливаа өөрчлөлтийг тогтмол тусган, бүртгэлийг шинэчлэх үүрэгтэй. Хэрэв аль нэг нам Ерөнхий Прокурорын газраас ирүүлсэн намын

2 Мөн тэнд. (56-р зүйл)

3 Мөн тэнд. (57-р зүйл)

4 <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.2709.pdf> (БНТУ-ын 1982 оны Үндсэн Хууль, 67-р зүйл)

5 The law of Turkey on Political Parties (1983), (Amendment 1999.8.12) Article 2. Provision 11.

6 The law of Turkey on Political Parties (1983), (Amendment 1999.8.12) Article 8.

өөрчлөлттэй холбоотой мэдээллээ заасан хугацааны дотор өгөөгүй тохиолдолд нэг удаа анхааруулга өгөх ба 2 удаагийн анхааруулгын дараа хариу ирүүлээгүй нөхцөлд Ерөнхий Прокурор тухайн улс төрийн намд төрөөс үзүүлэх дэмжлэгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хасах санал боловсруулж, шүүхэд хандан, хэрэг үүсгэх хүсэлт гаргах эрхтэй.⁷

Улс төрийн намын зохион байгуулалт нь төв, орон нутгийн салбар нэгж, мөн парламент дахь намын бүлэг, ерөнхий болон орон нутгийн салбар зөвлөлүүдээс бүрддэг. Төв ба нэгдмэл төрийн зарчмыг хангах үүднээс улс төрийн намуудын төв байгууллага нь нийслэл Анкара хотод байрладаг.⁸

Намын их хурал бол тухайн улс төрийн намын дээд удирдлага болохын хувьд намын дотоод бүтэц, бүрэлдэхүүнийг сонгож, мөрийн хөтөлбөр, төсөв батлах эрх, үүрэгтэйгээс гадна сайн дурын үндсэн дээр намын байгууллага татан буулгах, салгах, салбар байгуулах зэргээр бүтцийн өөрчлөлт хийх эрхтэй.

Улс төрийн намын тухай хуульд намуудын сонгуульд оролцох захиргааны болон зохион байгуулалтын үндсэн болон дэд стандарт, шаардлагууд, квот, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа, намын дүрмээр тусдаа зохицуулагдах бусад нарийвчилсан аспектиудыг мөн дэлгэрэнгүй тусгажээ.

7 Ibid. Article 102.

8 Ibid. Article 8.

9 Улс төрийн намын тухай хуулийн 19, 20-р зүйл

10 Мөн тэнд, 53-р зүйл

11 Nazli Erdem, “Siyasi Partilerin Finansmani ve mali denetimi”, D.E.U.Hukuk Fakultesi Dergisi. 2017, s.3105-3145

Сүүлийн жилүүдэд улс төрийн томоохон намуудын дунд түгээмэл үзэгдэл болсон намын орон нутгийн байгууллагыг татан буулгах,⁹ гишүүдийг огцруулах эрх¹⁰ нь намын удирдлагуудад хязгааргүй эрх мэдлийг олгож байгаа ба энэ нь нэг эсвэл хэсэг хүний манлайлал давамгайлахад хүргэж, нам доторх ардчиллын зарчмыг сулруулж байна гэж Турк судлаачид үздэг.

Улс төрийн намын санхүүжилт ба эрх зүйн зохицуулалт. Турк улсын улс төрийн намын санхүүжилтийн хэлбэр, хэмжээ түүнтэй холбогдон гарах аливаа харилцааг зохицуулж байсан туршлагыг 1961 оны Үндсэн хуулиас өмнө, хойно хэмээн хоёр үед хуваан авч үзэх боломжтой.

Дээр дурдсанчлан 1961 оны Үндсэн хууль батлагдах хүртэл улс төрийн намын үйл ажиллагааг Холбоодын тухай хуулиар зохицуулж байсан бөгөөд энэ хуулийн холбогдох заалтын дагуу улс төрийн намын санхүүжилт нь гишүүдийн төлбөр, хандив, төрийн дэмжлэг (мөнгөн бус) концерт, хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагаанаас олсон орлогоос зонхилон бүрдэж байв.¹¹

1961 оны Үндсэн хууль батлагдсаны дараа дээр дурдсан орлого, санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл нэмэгдэж, 1965 оны Улс төрийн намын тухай хуулийн 65-р зүйлд, 1983 онд Улс төрийн намын тухай хуулийн 61-р зүйлд улс төрийн намын орлого,

санхүүжилтийн төрөл, хэлбэрүүдийг дараах байдлаар тодорхой заажээ.

- *Намын гишүүдийн бүртгэлийн хураамж, жил, сар тутмын хураамж*
- *Парламентад сонгогдсон намын гишүүний хураамж, нэр дэвшихэд авах хураамж*
- *Намын туг, тэмдэг, таних тэмдэгтийн хураамж*
- *Намын орон нутаг дахь салбар нэгжүүдийн үйл ажиллагаанаас олсон орлого*
- *Нам санхүүжүүлж зохион байгуулсан хурал, концерт, спортын арга хэмжээнээс олсон орлого*
- *Нам санхүүжүүлж зохион байгуулсан сугалаа зэргээс олсон орлого*
- *Намын өмчлөлд буй эд хөрөнгөнөөс олсон орлого*
- *Хандив, зээл*
- *Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг*

1983 онд шинэчлэн батлагдсан Улс төрийн намын тухай хуулиар, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хувийн салбараас банк, санхүүгийн байгууллага түүнтэй ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага улс төрийн намд хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хандив өгөхийг хатуу хориглосон байна. Харин мэргэжлийн холбоо, нэгдэл, хоршоо, сан зэрэг ТББ-ууд хуульд заасан тоо хэмжээг үл

хэтрүүлэх нөхцөлтэйгөөр улс төрийн намд санхүүгийн дэмжлэг үзүүлж болдог. Аль ч улс төрийн нам гадаад улс орон, олон улсын байгууллага, гаднын иргэний байгуулсан ААН, сан, холбоо зэрэг байгууллагаас хандив авахыг хориглодог.

Улс төрийн намд *төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг* 1965 оны *Улс төрийн намын тухай* хуулийн 65-р зүйлд анх хуульчилсан байдаг. Энэ заалтаар *парламентын сонгуульд оролцож үндэсний хэмжээнд нийт хүчинтэй саналын 10 болон түүнээс дээш хувийн санал авсан эсвэл парламентад намын бүлэг байгуулах хангалттай суудал авсан (20) улс төрийн намуудын авсан саналын тоогоор хувь тэнцүүлэх замаар* улсын төсвөөс жил бүр олгох дэмжлэгийн хэмжээг¹² тодорхойлдог. 2000 оны эхэн үеэс хойших 10 гаран жилийн хугацаанд Турк улсын төсвөөс парламентад суудалтай намуудад олгосон санхүүгийн дэмжлэгийн мэдээллийг Хүснэгт 1-т дэлгэрэнгүй харуулав. Улс төрийн намын тухай хуульд төрөөс олгож буй дэмжлэг нь сонгуулийн үеэр ихэвчлэн өөрсдөө бие даан ажилладаг орон нутгийн, залуучуудын, эмэгтэйчүүдийн зэрэг төв намаасаа санхүүгийн дэмжлэгийг тогтмол авдаггүй намын нэгжүүдэд хэрхэн хуваарилагдах талаар зохицуулалт тусгагдаагүй байна гэх шүүмжлэл судлаачид, улс төр судлаачдын дунд түгээмэл байдаг.¹³

12 2021 оны улсын төсвөөс нийт 481 сая турк лирийн санхүүгийн дэмжлэгийг парламентад суудалтай 5 улс төрийн намд гишүүдийн тоонд харгалзуулан олгохоор шийдвэрлэсэн байна.

<https://www.cumhuriyet.com.tr/haber/siyasi-partilerin-hazineden-alacaklari-tutar-belli-oldu-1774946>

13 Ayan, P. (2009) *Theorizing Authoritarian Party Structures: The Case of Turkey*, Ph.D. dissertation, Bilkent University (Ankara), Turkey

Хүснэгт 1. Улс төрийн намуудад жил бүр төсвөөс олгосон дэмжлэг¹⁴

| Улс төрийн нам | 2001 | 2002 | 2003 | 2004 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 |
|---------------------------------|------|-------|------|-------|------|-------|-------|------|-------|------|-------|-------|-------|
| Зүүний ардчилсан нам | 5,5 | 28,8 | - | | | | | | | | | | |
| Төрөлх эх орон нам | - | 1,0 | - | | | | | | | | | | |
| Аз жаргал нам | 0,5 | 11,3 | - | | | | | | | | | | |
| Эрх чөлөө, эв нэгдлийн нам | - | 0,8 | - | | | | | | | | | | |
| Шударга ёс, хөгжлийн нам | 0,1 | 11,3 | 22,5 | 52,8 | 31,8 | 40,0 | 141,2 | 45,7 | 111,3 | 52,7 | 186,5 | 72,5 | 81,5 |
| Агуу нэгдэл нам | - | 1,2 | - | - | - | | - | | | | | | |
| Эх орон нам | 3,2 | 17,3 | - | - | 5,1 | 8,5 | - | | | | | | |
| Үндэсний хөдөлгөөн нам | 4,4 | 23,4 | 5,5 | 12,8 | 7,7 | 9,8 | 34,4 | 14,0 | 34,1 | 16,1 | 57,1 | 18,9 | 21,3 |
| Бүгд Найрамдах Ардын Нам нам | 2,1 | 11,3 | 12,7 | 29,9 | 18,0 | 22,7 | 79,9 | 20,4 | 49,9 | 23,6 | 83,6 | 37,8 | 42,5 |
| Социал демократ ардын нам | - | - | - | | 1,3 | - | - | | | | | | |
| Зөв зам нам | 2,9 | 15,7 | 6,3 | 14,7 | 8,8 | 11,1 | 39,3 | | | | | | |
| Ариун журам нам | 3,2 | - | - | - | | | | | | | | | |
| Залуучуудын нам | | | 4,8 | 11,1 | 6,7 | 8,5 | 29,9 | | | | | | |
| Нийт | 21,9 | 122,1 | 51,8 | 121,3 | 79,3 | 100,6 | 324,7 | 80,1 | 195,3 | 92,4 | 327,2 | 129,2 | 145,3 |

Тэмдэглэл: 2001-2004 онд хамаарах дүнг триллион турк лир буюу их наяд, 2005 оноос хойших дүнг сая шинэ турк лир гэж уншина. 12.2006 USD/TRY=1.41, 12.2007 USD/TRY=1.16, 12.2008 USD/TRY=1.53, 12.2009 USD/TRY=1.49, 12.2010 USD/TRY=1.54, 12.2011 USD/TRY=1.90, 12.2012 USD/TRY=1.78, 12.2013 USD/TRY=2.13¹⁵

¹⁴ Sources: Compiled from the Audit Court, *Treasury Operations Reports*, 2000-2010, the Replies of the Minister of Finance to the Oral Questions on State Aid, <http://www2.tbmm.gov.tr/d23/7/7-4697c.pdf> and <http://www2.tbmm.gov.tr/d24/7/7-17987c.pdf> and the 2013 General Budget. ¹⁵ <https://www.tcmb.gov.tr/wps/wcm/connect/EN/TCMB+EN/Main+Menu+Statistics/Exchange+Rates/Indicative+Exchange+Rates>

Улс төрийн намуудын хувьд тэр дундаа сонгуулийн кампанит ажлын үеэр цуглах хандив орлогын хоёр дахь эх үүсвэр болдог боловч бүгд бүртгэгддэггүй.

Хувь хүн, байгууллагаас улс төрийн намд үзүүлэх нэг удаагийн мөнгөн хандивын дээд хязгаарыг жил бүр Сангийн яам, Сонгуулийн Дээд зөвлөлөөс гаргасан шаардлага, тооцоололд үндэслэн тогтоодог бөгөөд 2013 онд 30,710 турк лира буюу ойролцоогоор 13,068 евро байжээ.

Улс төрийн намуудын үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төрийн шууд бус дэмжлэг байсны нэгэн жишээ бол улс төрийн намууд 1949 оноос эхлэн төрийн өмчийн олон нийтийн радиогоор үнэгүй мэдээлэл, сурталчилгаа дамжуулах эрхтэй байсан явдал бөгөөд уг эрхийг 1954 оноос эхлэн хуулиар хориглосон байна. 1961 оны Үндсэн хууль, холбогдох заалтууд хүчин төгөлдөр үйлчилж байх үед бүх улс төрийн нам парламентын сонгуулийн сурталчилгаа, суртал ухуулгаа олон нийтийн радио, телевизээр дамжуулах эрхтэй байсан боловч үүнд орон нутгийн сонгуулийн сурталчилгаа, ухуулга хамаардаггүй байжээ.¹⁶

Сонгуулийн кампанит ажил ба ухуулга, сурталчилгаа. 1980-д оны дунд үед хэд хэдэн хувийн телевизээр улс төрийн намын талаарх мэдээ, мэдээллийг ямар нэгэн зохицуулалтгүйгээр нэвтрүүлж байв. Харин удалгүй 1986 онд төрийн болон

хувийн өмчийн радио, телевизээр төлбөртэй сурталчилгаа хийх асуудлыг хуулиар зохицуулж эхэлжээ.¹⁷ Гэхдээ тухайн үед телевиз, радиогоор төлбөртэй сурталчилгаа явуулах нь санхүүгийн чадамжтай улс төрийн намуудад давуу эрх олгож байсан бөгөөд энэ нь Үндсэн хуульд заасан “тэгш байдал”-ын зарчмыг алдагдуулж байгаагаас гадна олон нийтийн радио, телевиз нь олон нийтийн байгууллага мөртөө төлбөртэй улс төрийн сурталчилгаа нэвтрүүлэх нь “төвийг сахих” зарчмыг мөн зөрчиж байна гэсэн шүүх байгууллага дүгнэжээ.

Олон нийтийн радио, телевизээр цацагдах нэвтрүүлэгт тавих хяналт, төрийн зохицуулалтыг сайжруулах, үүсээд байсан эмх замбараагүй байдлыг зохицуулах зорилгоор Үндэсний Радио, Телевиз байгуулах, өргөн нэвтрүүлгийн тухай¹⁸ хуулийг 1994 онд шинэчлэн баталсан юм. Энэ хуулиар сонгуулийн ухуулга, сурталчилгааны нэвтрүүлгийг Радио, Телевизийн Дээд Зөвлөл зохицуулж, хяналт тавина. Мөн хуулиар парламентын сонгуульд оролцож буй улс төрийн хүчнүүдэд радио болон телевизийн сувгаар мэдээлэл, сурталчилгаа нэвтрүүлэх тодорхой цаг хуваарилсан боловч орон нутгийн сонгуульд оролцоход энэ зохицуулалт хамаардаггүй. Сонгуулийн тухай хуулийн дагуу “сонгуульд оролцож буй улс төрийн нам тус бүр хоёр удаа ухуулга, сурталчилгааны нэвтрүүлэг цацах эрхтэй бөгөөд эхний нэвтрүүлгийг санал хураалт

16 1961 оны Сонгуулийн тухай 298 тоот хууль, 52-55-р зүйл.

17 Радио, телевизийн сувгаар төлбөртэй мэдээлэл цацах тухай 3330 тоот хууль.

18 Үндэсний Радио, ТВ байгуулах, өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 27-р зүйл

явагдах өдрөөс 7 хоногийн өмнө орон нутгийн цагаар оройны 18 цаг хүртэл, хоёр дахь нэвтрүүлгийг сонгуулийн санал хураах өдрийн өмнөх өдөр байхаар хуульчилсан бөгөөд суртал нэвтрүүлгийн урт тус бүр 10 минутаас

хэтрэхгүй байна” гэж заажээ. Эдгээр суртал ухуулга, сурталчилгаа бүхий нэвтрүүлгүүдийг дуу, дүрсний бүрэн бичлэгийн хамт бусад бүх төрлийн радио, телевизээр нэвтрүүлж болно.

1.2 Олон намын тогтолцоонд шилжих үеийн улс төрийн намын хөгжил

Олон намын тогтолцоонд шилжихээс өмнө буюу 1940-өөд оны эхэн үе хүртэлх Туркийн улс төрийн намын хөгжил, төлөвшлийг харахад нэг нам ноёлсон, монолитик бүтэцтэй байв. Бүгд найрамдах улс байгуулагдсан эхний он жилүүдэд нэг намын тогтолцоо бүхий нэгдсэн улс байгуулах явдлыг ард түмэн төдийлөн дэмжиж байгаагүй бөгөөд 1925 онд *Шэйх Саийтийн бослого* зэрэг улс төрийн үзэл санааны хувьд эрх баригч намаас өөр байр суурьтай улс төрийн, хувьсгалт хүчний үйл ажиллагаа эрчимжсэн нь ард иргэдийн дунд айдас, эргэлзээг бий болгож, улс төрийн шинэ нам байгуулах

урам, зоригийг мохоож байв. Улмаар анхны сөрөг хүчин болж гарч ирсэн Тетракипервер Бүгд Найрамдах Нам 1925 онд байгуулагдаад 5 сарын дараа хаагджээ.

Ийнхүү улс төрийн шинэ хүчин байгуулах оролдлого ихэнх тохиолдолд амжилтгүй болсоор 1950-иад оноос хойших 50 орчим жилийн хугацаанд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр 20 гаран улс төрийн намыг хаажээ. Туркийн ҮИХ-ын Судалгааны төвийн бэлтгэсэн тайланд дурдсанаар эдгээр улс төрийн намыг дараах үндсэн хоёр шалтгааны улмаас хааж, үйл ажиллагааг нь зогсоосон байдаг. (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Үндсэн Хуулийн Шүүхийн шийдвэрээр хаагдсан улс төрийн намууд

| | Улс төрийн нам | Үзэл баримтлал | Хаагдсан он | Хаагдсан шалтгаан |
|----|------------------------------|----------------|-------------|---|
| 1 | Туркийн Социалист нам | Хэт барууны | 1952 | нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзлийг дэлгэрүүлсэн |
| 2 | Кемалист залуучуудын нам | Хэт барууны | 1966 | нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзлийг дэлгэрүүлсэн |
| 3 | Ажилчин, Тариачны Нам | Хэт барууны | 1968 | нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзлийг дэлгэрүүлсэн |
| 4 | Туркийн Идеалист Нам | Хэт баруун | 1971 | нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзлийг дэлгэрүүлсэн |
| 5 | Туркийн Ажилчны Нам | Хэт зүүн | 1972 | Хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй |
| 6 | Үндэсний Дэг журмын Нам | Хэт зүүн | 1972 | Хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй |
| 7 | Эрх чөлөө ба Үндэсний Нам | Хэт баруун | 1981 | нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзлийг дэлгэрүүлсэн |
| 8 | Шударга ёс нам | Баруун төв | 1981 | нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзлийг дэлгэрүүлсэн |
| 9 | Эрх чөлөөт ардчилгачдын нам | Баруун төв | 1981 | нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзлийг дэлгэрүүлсэн |
| 10 | Бүгд Найрамдах Ардын Нам нам | Баруун төв | 1991 | Хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй |
| 11 | Ногоон Нам | Зүүн | 1994 | Хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй |
| 12 | Социалист Эв нэгдлийн Нам | Хэт зүүн | 1994 | Хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй |
| 13 | Шинэ эхлэл нам | Хэт баруун | 1996 | Хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй |
| 14 | Ардчилал ба өөрчлөлт нам | Зүүн | 1996 | Хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй |
| 15 | Хөдөлмөрийн нам | Хэт баруун | 1997 | Хуульд заасан шаардлага, шалгуур хангаагүй |
| 16 | Аз жаргал нам | Баруун | 2001 | нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзлийг дэлгэрүүлсэн |
| 17 | Ардын Ардчилсан Нам | Зүүн | 2003 | нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзлийг дэлгэрүүлсэн |

Улс төрийн намын тогтолцооны өнөөгийн хөгжил, сонгуулийн дүрэм.

Бүгд Найрамдах Турк Улс нь олон тойрогт пропорциональ системээр сонгогдсон 81 мужийг төлөөлөх 550 гишүүдээс бүрдсэн нэг танхимтай хууль тогтоох байгууллагатай байсан бол 2017 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөс хойш 81 мужийг төлөөлөх нийт 600 гишүүдээс бүрдсэн нэг танхим бүхий хууль тогтоох байгууллагатай болж өөрчлөгдөв.

1982 оны Үндсэн хуульд Туркийн Үндэсний Их Хурал (ҮИХ) болон орон нутгийн төлөөллийн байгууллагыг нийтийн, шууд, чөлөөт ардчилсан зарчимд суурилсан сонгуулиар байгуулах тухай заасан байдаг бөгөөд үүнд “тэгш эрхийн зарчимд суурилсан, улс төрийн намуудын шударга төлөөллийг хангах” зэрэг үндсэн санаа мөн тусжээ.

Сонгуульд оролцох эрх авахын тулд улс төрийн намууд орон нутгийн салбар, нэгжээ нийт 81 мужийн тал хувьд, дүүргүүдийн гуравны нэгт байгуулсан байх ёстой. Сонгуулийн санал хураалт болох өдрөөс 6 сарын өмнө намын их хурлаа хийсэн байх, эсвэл парламентад намын бүлэгтэй байх зэрэг шаардлагыг хангасан байх учиртай.

Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу Сонгуулийн Дээд Зөвлөл нь сонгуульд орох эрхтэй улс төрийн намуудын нэрийг эцэслэн гаргах үүрэгтэй бөгөөд сонгуульд өрсөлдөх эрх авах улс төрийн намуудад тавих шаардлагыг Үндсэн хууль болон холбогдох бусад хуульд

тодорхой заажээ.¹⁹

Улс төрийн намууд сонгуульд нэр дэвшигчээ сонгохдоо намын дүрэм, үйл ажиллагааныхаа үндсэн зарчимд тулгуурлан санал хурааж, эцэслэдэг. Гэвч практикт ихэнх улс төрийн нам (удирдагчид) сонгуульд нэр дэвшигчийг эрэмбэлэх, сонгох, санал хураах үйл ажиллагааг улс төрийн намын гүйцэтгэх алба болох хороогоор дамжуулан шийдвэрлэх нь элбэг.

2002 онд болсон парламентын сонгуульд нийт 18 улс төрийн нам оролцохоор бүртгүүлсэн ч эдгээрээс зөвхөн 2 улс төрийн нам шаардлагатай санал авч, Туркийн ҮИХ-д төлөөлөлтэй болсон байдаг. Шударга ёс, хөгжлийн нам (ШЁХН) хүчинтэй саналын 34,26 хувийг авсан бөгөөд 363 суудлыг баталгаажуулсан бол (66 хувь) Бүгд найрамдахчуудын ардын нам (БНАН) нийт хүчинтэй саналын 19,4 хувийг авч, парламентад 178 суудалтай нам болсон юм.

Эдгээр намуудаас гадна улс төрийн 4 хүчин нийт саналын 5-9.5%-ийг авч чадсан ч парламентад суудалтай болж чадаагүй байна. Энэ сонгуульд Ардын ардчилсан нам (ААН), Курдын үндэсний нам Турк улсын зүүн болон зүүн өмнөд хэсэгт байрлах мужуудаас 13 мужид нийт сонгогчдын 20 гаруй хувийн санал авсан ба үүнээс таван мужид авсан саналын тоо 40-с дээш хувийг давсан боловч үндэсний хэмжээнд нийт саналын 10 хувийг авах босгыг даваагүй учир парламентад суудал авч чадаагүй юм.

Ер нь улс төрийн хүчнийг дэмжигч иргэд, олон нийтийг оршин суугаа,

19 Орон нутгийн захиргааны сонгуулийн тухай 2972 тоот хуулийн 9-10-р зүйлд тус тус жагсаасан байдаг.

хаяг, байршил, мужаар ангилан харвал, зүүн төвийн үзэл баримтлалыг дэмжигч Бүгд найрамдахчуудын ардын намыг нутгийн баруун бүсийн цөөн хэдэн муж түлхүү дэмждэг бол нутгийн төв, хойд, өмнөд хэсгээр, өөрөөр хэлбэл Анатолийн тал нутагт хамаарах муж, хотуудын ард иргэд өдгөө төрийн эрх барьж буй Шударга ёс, хөгжлийн намын тууштай дэмжигчид байгаа нь ажиглагдана.

Харин Үндэсний Хөдөлгөөний Нам (ҮХН) курдуудын эрх ашгийг түлхүү хамгаалдаг, хэт зүүний үзэл баримтлалтай, үндэсний цөөнхийн эрх ашгийг хамгаалсан сонгогчид нутгийн зүүн болон зүүн өмнөд хэсэг буюу Иран, Сири улстай хил залгаа оршдог мужуудад түгээмэл ажиглагдаж байна. (Зураг 1.)


Тус улсад бие даан нэр дэвшигч харьцангуй хожуу буюу 2000-д оны

дунд үеэс улс төрийн идэвхтэй тоглогч болж орж ирсэн байдаг.²⁰ Жишээлбэл, 2002 онд 190 бие даан нэр дэвшигч байснаас зөвхөн 9 нь парламентад сонгогдсон бол 2007 онд болсон парламентын сонгуулиар нийт 26 бие даан нэр дэвшигч, 2011 онд 34 бие даан нэр дэвшигч парламентад сонгогдож байв. Харин 2018 оны сонгуулиар 10 бие даан нэр дэвшигч сонгогдсон байна.²¹

2000-оноос хойш идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намууд. Турк улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намын тоо жил тутам нэмэгдэж байгаа ч тэдгээрийн зарим нь төрөл бүрийн шалтгаанаар улс төрөөс гарахаас өөр аргагүй байдалд ордог. Тухайлбал, 2015 оны бүртгэлээс харахад 60 гаран бүртгэлтэй улс төрийн нам идэвхтэй

Зураг 1. 2018 оны парламентын сонгуульд санал авсан улс төрийн намууд, засаг захиргааны нэгж, мужаар²⁰

| | | |
|--------------------------------|-----|--------|
| Шударга ёс хөгжлийн нам | 295 | ↓42,6% |
| 2015.11.1-ны сонгуульд | 317 | 49,5% |
| Бүгд Найрамдахчуудын Ардын нам | 146 | ↓22,6% |
| 2015.11.1-ны сонгуульд | 134 | 25,3% |
| Ардын Ардчилсан нам | 67 | ↓11,7% |
| 2015.11.1-ны сонгуульд | 59 | 10,8% |
| Үндэсний Хөдөлгөөний нам | 49 | ↓11,1 |
| 2015.11.1-ны сонгуульд | 40 | 11,9% |
| Сайн нам | 43 | ↓10% |
| 2015.11.1-ны сонгуульд | 0 | 0 |
| Аз жаргал нам | 0 | 1,3% |
| 2015.11.1-ны сонгуульд | 0 | 0,7% |
| HÜDA-PAR | 0 | 0,3% |
| 2015.11.1-ны сонгуульд | 0 | 0 |
| Эх орон нам | 0 | 0,2% |
| 2015.11.1-ны сонгуульд | 0 | 0,2% |
| Бусад нам | 0 | 0,2% |
| 2015.11.1-ны сонгуульд | 0 | 1,6% |



20 <https://www.yenisafak.com/en/secim-2018/secim-sonuclari>

21 https://www.tbmm.gov.tr/develop/owa/milletvekillerimiz_sd.dagilim

үйл ажиллагаа явуулж байсан бол 2021 оны байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 108 улс төрийн нам тус улсын Дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн байна.

2021 оны 2 дугаар сарын 21-ны өдрийн байдлаар²² Турк улсад идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 108 улс төрийн нам бүртгэлтэй байгаа бөгөөд идэвхтэй үйл ажиллагаа гэдэгт дээр дурдсанчлан намын их хурлаа тогтмол зохион байгуулахаас гадна улс төрийн үзэл санаа, философи, чиг шугамаа олон нийтэд таниулах үйл ажиллагааг тогтмол хийх зэргийг багтаан ойлгож болно. Мөн түүнчлэн эдгээр улс төрийн намууд сонгуульд оролцох эрхээ авахын тулд хуульд заасан шаардлагын дагуу нийт 81 мужийн 41 мужид нь салбар хороодоо нээсэн, тэдгээр нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байх ёстой.

Албан ёсны бүртгэлтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 100 гаруй улс төрийн намаас өдгөө эрх баригч ШЁХН, БНАН, ҮХН, Курд үндэстний эрх ашгийг түлхүү хамгаалдаг Ардын Ардчилсан Нам (ААН), Сайн Нам гэсэн 5 том улс төрийн нам сонгогчдын

тодорхой хэсгийн дэмжлэгийг авч парламентад суудал авдаг жишиг сүүлийн 2-3 удаагийн парламентын сонгуулийн үр дүнгээс харагдаж байна.

2015 оны 6 дугаар сард болсон парламентын сонгуулиар аль ч нам олонхын санал авч чадаагүй учраас хамгийн олон санал авсан ШЁХН бусад намуудтай зөвшилцөн эвслийн засгийн газар байгуулах нөхцөл байдал үүссэн байна. Харамсалтай нь зөвшилцөх үйл явц амжилтгүй болсон учраас 2015 оны 11 дүгээр сард парламентын сонгуулийг дахин явуулж ШЁХН олонхын санал авч байв.

Харин 2017 оны Үндсэн хуулийн өөрчлөлтөөр хууль тогтоох байгууллагын болон ерөнхийлөгчийн сонгуулийг нэг жил явуулах хууль эрх зүйн орчин бий болж, 2018 оны 6 дугаар сард ерөнхийлөгчийн болон парламентын сонгууль зэрэг явагдаж, ерөнхийлөгчөөр Рэжэп Тайип Эрдоан сонгогдсон ч, түүний нам олонх болж чадаагүй тул Үндэсний хөдөлгөөний намтай хамтарч Ардын эвслийн засгийн газрыг байгуулав. Ийнхүү 2002 оноос хойш дөрвөн удаагийн бүрэн эрхийн хугацаанд ШЁХН тасралтгүй

Хүснэгт 3. Туркийн ҮИХ-ын 2015 оны сонгуулиар намуудын авсан суудлын тоо

| № | Сонгуульд оролцсон улс төрийн намууд | Парламентэд авсан суудлын тоо | |
|---|---------------------------------------|-------------------------------|-------------------|
| | | 2015 оны 6-р сар | 2015 оны 11-р сар |
| 1 | Шударга ёс, хөгжлийн нам (ШЁХН) | 258 | 317 |
| 2 | Бүгд найрамдахчуудын ардын нам (БНАН) | 132 | 134 |
| 3 | Үндэсний хөдөлгөөний нам (ҮХН) | 80 | 40 |
| 4 | Ардын ардчилсан нам (ААН) | 80 | 59 |

²² <https://www.yargitaycb.gov.tr/documents/ek1-1613975687.pdf> (БНТУ-ын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас)

дангаар Турк улсын төр, засгийн эрх барьсан уламжлал эвдэгдсэн юм. Энэ нь хүний эрх, олон ургалч үзэл, ардчилсан засаглалыг эрхэмлэгч олон улс орнуудад төдийлөн түгээмэл ажиглагддаг улс төрийн үзэгдэл биш бөгөөд тус нам дангаараа эрх барьж байсан сүүлийн жилүүдэд тус улсын нийгэм, улс төрийн амьдралд нэг намын давамгайлал илт ажиглагдах болсон билээ.

Улмаар 2018 оны сонгуулийн дараагаар тус намын гишүүн, улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан Али Бабажан, Ахмет Давутоглу зэрэг улс төрчдийг дэмжигч гишүүд болон намын удирдлага хоорондын улс төрийн үзэл суртал, арга, хандлагын хувьд зөрчил, ялгаатай талууд улам бүр нэмэгдэж, 2019, 2020 онд эдгээр улс төрчид, намаасаа гарч, ДЭВА, Ирээдүй Нам зэрэг улс төрийн шинэ хүчин байгуулснаа албан ёсоор мэдэгдсэн юм.

Сүүлийн жилүүдэд тасралтгүй эрх барьж буй ШЁХН бол улс төрийн үзэл баримтлалын хувьд ардчиллын консерватив чиг шугам баримталж, түүнийгээ парламент, Засгийн

газар, Ерөнхийлөгчийн институцээр дамжуулсан нэгдмэл цогц бодлогоор хэрэгжүүлдэг хэмээн намын баримт бичигтээ тодорхойлсон байдаг. 1990-ээд оны сүүл үе буюу тус улсын дотоод улс төрийн амьдралд анх гарч ирэхдээ улс орныхоо дотоодод болон бүс нутаг, олон улсын хэмжээнд ардчилал, хүний эрх, эрх зүйт төр, нийгмийн шударга ёсыг баталгаажуулахад чиглэсэн үзэл баримтлалыг тууштай дэмжиж гарч ирсэн юм. Гэвч барууны болон зарим турк судлаачдын дүгнэж байгаагаар энэ нам хүний эрх, шударга ёсыг дээдэлсэн ардчилсан нийгэм, эрх зүйт төрийг цогцлооно хэмээн уриалж, амлалт өгч байсан нь зөвхөн төр, засгийн эрхэнд гарч ирэх үндсэн хэрэгсэл нь байсан бол улмаар хүчирхэгжиж, хязгааргүй эрх мэдэлтэй болох тусам анхнаасаа исламын шашны үнэт зүйлс, зарчмыг дэмждэг улс төрийн хүчин байсан нь тодорхой болж байна гэж дүгнэжээ. Туркийн УИХ-д суудалтай бусад улс төрийн намуудын нэр, удирдлага, улс төрийн үзэл баримтлалын чиг шугам, орон нутаг дахь төлөөлөл зэрэг мэдээллийг дараах хүснэгтэд товч хураангуйлав.

Хүснэгт 4. Туркийн УИХ-ын 2018 оны сонгуулиар намуудын авсан суудлын тоо

| № | Сонгуульд оролцсон улс төрийн намууд | Парламентад авсан суудлын тоо |
|---|---------------------------------------|-------------------------------|
| | | 2018 оны 6-р сар |
| 1 | Шударга ёс, хөгжлийн нам (ШЁХН) | 295 |
| 2 | Бүгд найрамдахчуудын ардын нам (БНАН) | 146 |
| 3 | Үндэсний хөдөлгөөний нам (ҮХН) | 49 |
| 4 | Ардын ардчилсан нам (ААН) | 67 |
| 5 | Сайн Нам | 43 |

Хүснэгт 5. Туркийн УИХ-д суудалтай улс төрийн намууд

| Улс төрийн намын нэр | | Намын дарга | Улс төрийн чиг баримжаа | Улс төрийн үзэл санаа | УИХ дахь гишүүдийн тоо | Том хотын удирдлага |
|----------------------|-----------|--------------------------------|-----------------------------|-----------------------|---|---------------------|
| 1 | AK Parti | Шударга Ёс, Хөгжлийн нам | Рэжэп Тайип Эрдоган | Баруун | Үндсэрхэг ардчилсан, шинэ османы үзэл | 295/600 15 / 30 |
| 2 | CHP | Бүгд Найрамдахчуудын Ардын Нам | Кемал Киличдароглу | Зүүн төв | Социал демократ, Нийгмийн ардчилал, Ататуркийн үзэл санаа | 146/600 11 / 30 |
| 3 | HDP | Ардын Ардчилсан Нам | Митхат Санжар Пэрвин Булдан | Зүүн | Радикал ардчилал олон ургалч үзэл | 67/600 0 / 30 |
| 4 | MHP | Үндэсний Хөдөлгөөний Нам | Дэвлэт Бахчели | Хэт баруун | Үндэсний үзэл, үндэсний цөөнх, курдууд | 49/600 1 / 30 |
| 5 | İYİ Parti | Сайн нам | Мэрал Акшэнэр | Баруун төв | Ататурк, үндэсний үзэл, нийгмийн шударга ёс | 43/600 0 / 30 |

<https://www.ysk.gov.tr/tr/2018-cumhurbaskani-ve-milletvekili-secim-i%CC%87statistikleri/78032>

Гэхдээ Туркийн улс төрийн амьдралд эдгээр том намуудтай харьцуулахад харьцангуй цөөн гишүүдтэй, салбар хороодтой боловч

улс төрд нэр, нөлөө ихтэй жижиг улс төрийн намууд тодорхой үүрэгтэй байх нь элбэг тохиолдоно.

Хүснэгт 6. Туркийн ҮИХ-ийн сонгуулийн дүн: 1983-2018 он ²³

TÜRKİYE

| | 1983 | 1987 | 1991 | 1995 | 1999 | 2002 | 2007 | 2011 | 6/7/2015 | 11/1/2015 | 2018 |
|---|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|------------|
| Бүртгэлтэй сонгогчдын тоо | 19 767 366 | 26 376 926 | 29 979 123 | 34 155 981 | 37 495 217 | 41 407 027 | 42 799 303 | 52 806 322 | 56 608 817 | 56 949 009 | 59 367 469 |
| Сонгуульд оролцсон иргэдийн тоо | 18 238 362 | 24 603 541 | 25 157 089 | 29 101 469 | 32 656 070 | 32 768 161 | 36 056 293 | 43 914 948 | 47 507 467 | 48 537 695 | 51 189 444 |
| Оролцооны түвшин (%) | 92.3 | 93.3 | 83.9 | 85.2 | 87.1 | 79.1 | 84.2 | 83.2 | 83.9 | 85.2 | 86.2 |
| Хүчинтэй санал | 17 351 510 | 23 923 687 | 24 371 474 | 28 040 392 | 31 119 242 | 31 414 748 | 34 822 907 | 42 813 896 | 45 121 773 | 46 555 267 | 48 631 366 |
| Гадаад улс, хил дээр өгсөн хүчинтэй санал | - | 47 942 | 45 192 | 86 601 | 65 254 | 114 035 | 226 784 | 127 867 | 1 041 470 | 1 284 964 | 1 505 809 |
| Нийт хүчинтэй санал | 17 351 510 | 23 971 629 | 24 416 666 | 28 126 993 | 31 184 496 | 31 528 783 | 35 049 691 | 42 941 763 | 46 163 243 | 47 840 231 | 50 137 175 |
| Сонгогдсон төлөөлөл, гишүүд | 399 | 450 | 450 | 550 | 550 | 550 | 550 | 550 | 550 | 550 | 600 |

²³ Туркийн Статистикийн Институтгийн цахим хуудас: <https://data.tuik.gov.tr/Kategori/GetKategori?p=adalet-ve-secim-110&dil=1>

Дүгнэлт

Дээр дурдсан бүхнийг нэгтгэн дараах хэдэн зарчмын дүгнэлт хийж болох байна.

Нэгдүгээрт, бүгд найрамдах улс байгуулсан цагаас хойш буюу 1920-иод оноос олон арван жилийн турш оршин тогтнож байсан нэг намын тогтолцоог халж, өөрчлөх гэсэн Туркийн ард түмний нийгэм, сэтгэлзүйн уур амьсгал нь 1940-өөд оны дунд үед шинэ тутам үүсэн бүрэлдэж байсан улс төрийн намуудын үзэл баримтлалын суурь болж байсан.

Хоёрдугаарт, шинээр бүрэлдэн тогтсон улс төрийн намууд тухайн үедээ үндэсний хэмжээнд өөрийн зохион байгуулалтын бүтцээ бүрдүүлж амжаагүй, цэгцрээгүй байсан бол олон улсын түвшинд тэр дундаа баруун Европын улс орнууд дахь улс төрийн намын хөгжил, төлөвшил, онолын үзэл баримтлал нь Турк улсад 1960-аад оны үед үүсэн байгуулагдсан улс төрийн намуудын үзэл баримтлал цэгцтэй бүрэлдэн тогтоход тодорхой хэмжээнд нөлөөлжээ.

1940-1990-ээд оны хооронд тус улсад улс төрийн олон намын тогтолцоо бүрэлдэн, боловсронгуй болж, намын үзэл суртал, чиг баримжаа тогтоход баруун Европын орнуудын либерал, социал демократ үзэл санаа нөлөөлсний дээр исламын ертөнц буюу Ойрх Дорнодод өрнөсөн хэт зүүний үзэл баримтлалын үүсэл, хөгжил, ажилчин ангийн тэмцэл, шашны нөлөө бүхий улс төрийн үзэл хандлага ч мөн тодорхой хэмжээнд нөлөөлж, бүгд найрамдах улсын

үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулах, нийгмийг хагаралдуулж, салан тусгаарлах үзэл, хандлагыг дэлгэрүүлэх зэрэг эрсдлийг бий болгож байв.

Харин 1990-2010 он хүртэлх 20 орчим жил тус улсын дотоод улс төрийн амьдрал харьцангуй тогтвортой, эдийн засгийн хөгжил, бүтээн байгуулалтад түлхүү анхаарсан он жилүүд байсан ч өдгөө бий болсон нэг намын нөлөө өргөжин тэлэх, нэг субъектэд засаглалын эрх мэдэл хэт төвлөрөх хандлага, үйл явцын эхлэл 2000-аад оны дунд үеэс тавигдсаныг Үндсэн хуульдаа хийсэн удаа дараагийн өөрчлөлтөөс харж болно.

БНТУ-ын Үндсэн хуульд 2017 онд оруулсан багц өөрчлөлтөөс сонгууль, улс төрийн намд хамаарах дараах үндсэн өөрчлөлт оржээ. Үүнд: Үндсэн хуулийн 76-р зүйлд заасан Туркийн ҮИХ-ын гишүүнд нэр дэвших насны доод хязгаар 25 нас байсныг 18 нас болгон өөрчлөх, 77-р зүйлд заасан Туркийн ҮИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийг 5 жил тутамд нэг өдөр зохион байгуулах зэрэг заалтууд багтана. Харин ерөнхийлөгчийн бүрэн эрх хэт нэмэгдэх, шүүх засаглалын хараат байдал бус байдал, хууль тогтоох байгууллагын гүйцэтгэх засаглалд тавих хяналт зэргийг сулруулсан нь ухралт болсон гэж судлаачид үздэг.

Эдгээр нэмэлт өөрчлөлт нь эрх зүйт төр, төлөөллийн ардчилал, парламентад ёс, эрх мэдлийн тэгш хуваарилалт, хүчний тэнцвэрийг

хангах зэрэг ардчилсан нийгмийн үнэт зүйлсийг үнэгүйдүүлсэн, эрх мэдлийн хэт төвлөрлийг бий болгосон өөрчлөлт болсон гэж судлаачид дүгнэсэн байдаг нь анхааран үзэх асуудал мөн.

Үүнээс гадна 2003 оноос хойш ШЕХН төрийн эрх барьсан 20 орчим жилийн хугацаанд ардчилсан, эрх чөлөөт нийгмийн хэв шинж улам бүр бүдгэрч, дотоод улс төрийн амьдралд улс төрийн ислам буюу улс төрд шашны нөлөө, үзэл суртал илт давамгайлах болсон нь тус улсын гадаад бодлогод тодорхой хэмжээнд тусгалаа олж, ЕХ-д нэгдэх гадаад бодлогын тэргүүлэх чиглэлтэй зэрэгцэх Ази, тэр дундаа төв Азийн бүс нутагт тус улс нөлөөгөө тогтоох бодлого

эрчимжих хөрс, суурийг бэлтгэж байж болох юм.

Нэг улс төрийн намын нөлөө, цар хүрээ аливаа улс, үндэстний нийгэм, соёл, улс төрийн амьдралд гүн нэвтэрч, түүнээс ялгаатай улс төрийн үзэл, хандлагыг үгүйсгэх нь нөлөөгөө тэлэн, бүс нутгийн төдийгүй дэлхийд жин нөлөө бүхий улс болох зорилготой Турк улсад төдийлөн нааштай өөрчлөлт авчрахгүй байх магадлалтай. Харин улс төрийн олон ургалч үзэл, хууль эрх зүйн хүрээнд дуу хоолойгоо хүчтэй сонсгож чадах бие даасан улс төрийн сөрөг хүчин, хэвлэлийн эрх чөлөө байсан цагт дээрх зорилт биелэх боломжтой юм.

Ашигласан материал

А. Нэг сэдэвт бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Abdurrahman Eren, “Turkiye`de Uygulanan %10 genel secim barajlarinin serbest secim hakkini ihlal sorunu”, (*Турк улс дахь парламентын сонгуульд тавигдаж буй 10 хувийн квот нь чөлөөт сонгууль явуулах зарчим зөрчиж байгаа нь*) 2008.
2. Ayan, P. (2009) Theorizing Authoritarian Party Structures: The Case of Turkey, Unpublished, Ph.D. dissertation, Bilkent University (Ankara), Turkey.
3. Cengiz Sari, “Siyasi Partiler ve Secim Kampanyalarinin finansmanin Kadin adaylarin secilmeleri uzerindeki etkisi”, 2020
4. Esen, B. (2015). Ergun Özbudun, Party Politics and Social Cleavages in Turkey (Boulder, Colo.: Lynne Rienner, 2013). International Journal of Middle East Studies, 47(1), 207-210. doi:10.1017/S0020743814001731
5. Ergun Ozbudun, “Contemporary Turkish Politics: Challenges to Democratic Consolidation”, Cambridge University Press, 2000
6. Ergun Özbudun, “Party politics and Social Cleavage in Turkey”, Cambridge University Press, 2013
7. Fazil Saglam, “Siyasi Partiler Kanunu`nda uluslar arasi standartlara uygunluk saglamak icin yapilmasi gereken degisikler”, (*Улс төрийн намуудын тухай хуулинд олон улсын стандарт нийцүүлэн засах шаардлагатай заалтууд*) 2008.

8. Nahit Yuksel, “Siyasetin Kamusal Finansmani (Siyasal Partilere Devlet Yardimi)”, 2007 (*Улс төрийн намуудад төрөөс үзүүлэх дэмжлэг*)
9. Sabri Sayarı, Pelin Ayan Musil, Ozhan Demirkol, “Party Politics in Turkey: A Comparative Perspective”, 2018.
10. Sabri Sayarı, Party Politics in Turkey: A Comparative Perspective, 2018.
11. Rubin and Neper, 2002; Sayarı, 2008; Oder, 2009; Ayan, 2011; Özbudun, 2013 and Yardımcı-Geyikdağı, 2013.

Б. Хууль, эрх зүйн баримт бичгүүд

12. БНТУ-ын 1982 оны Үндсэн хууль
13. БНТУ-ын 1983 оны Улс төрийн намын тухай хууль
14. БНТУ-ын 1961 оны Сонгуулийн тухай хууль
15. БНТУ-ын Үндэсний Радио, Телевизийн тухай хууль
16. Радио, телевизийн сувгаар төлбөртэй мэдээлэл цацах тухай 3330 тоот хууль
17. Радио, Телевиз байгуулах, өргөн нэвтрүүлгийн тухай хууль

В. Албан ёсны цахим эх сурвалжууд

18. <https://data.tuik.gov.tr/Kategori/GetKategori?p=adalet-ve-secim-110&dil=1>
Туркийн Статистикийн Институтийн цахим хуудас
19. <http://www2.tbmm.gov.tr/d24/7/7-17987c.pdf>
БНТУ-ын Үндэсний Их Хурлын цахим хуудас)
20. <https://www.yargitaycb.gov.tr/documents/ek1-1613975687.pdf>
БНТУ-ын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас
21. <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.2709.pdf> (хууль, тогтоол, дүрэм журмын нэгдсэн сан)

An establishment and development of political parties in the Republic of Turkey

Tserennadmid Chuluunbaatar

*Ph.D, Head, Department of Third Neighbor Studies, Institute of International
Studies, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia
tserennadmidch@mas.ac.mn*

Abstract: *This article discusses the origins and development of political parties in the Republic of Turkey, the political forces in Turkey during Ataturk's period, and the political turmoil in Turkey during the second half of the XX century. The article includes detailed research on the struggle for the survival, in some cases, the forced closure of certain political parties and groups in Turkey, a country with a distinctive Islamic and Western oriented society.*

In this regards, this article aims to explain in detail, how the method of operation was followed, what political parties and groups have been emerged, what positions do they occupy in the political system, how did they affect social and political spheres, structure, organizational characteristics of Turkey.

The topic was selected explore the following facts and factors: at first, to show the reasons and historical circumstances of the formation of the first political party, to identify the role and places of parties in the political and social life, thirdly, to clarify the reasons for the formation of a multi-party system; Fourth, it sets out the specifics of the development of major political parties in Turkey since 1990s.

Key words: *Political parties, ideologies, development trends, history of thought, historical chronology*

The day of submission: 2021.08.19

Completion of review: 2021.10.28

Final decision for acceptance: 2021.11.22